

“ХААН СОЁМБО АУДИТ”- ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/105/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Хөвсгөл аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Х.Энхтуяа
Утас: 89182456 Цахим хаяг: enkhtuyakh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Ахлах аудитор: Г.Заяа
Утас: 95648028, 98828028
Цахим хаяг: zaya96884510@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/217
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
О.ДААРИЙМАА ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвөөс санхүүжих дүнг 102,804.5 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс санхүүжих дүнг 4,428.1 мянган төгрөгөөр тус тус дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой түлш халаалтын зардлын 174,803.0 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 4,212.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлэн холбогдох шийдвэрийг гаргасан.

Бусад асуудлын хэсэг

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 25 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 80 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлан</i>		<i>/төгрөгөөр/</i>
Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>454,036,949.99</u>	<u>387,750,864.00</u>
МӨНГӨН ХӨРӨНГӨ	178,375,038.72	69,558,458.70
Банкинд байгаа бэлэн мөнгө	178,375,038.72	69,558,458.70
Төгрөг	178,375,038.72	69,558,458.70
Төрийн сангийн харилцах	178,375,038.72	69,558,458.70
БАРАА МАТЕРИАЛ	272,824,776.02	300,814,935.17
Түүхий эд материал	874,200.00	
Эм боох материал	874,200.00	
Хангамжийн материал	271,950,576.02	300,814,935.17
Бичиг хэргийн материал	2,718,650.00	3,815,650.00
Аж ахуйн материал	40,811,924.02	41,450,524.02
Түлш, шатах тослох материал	2,600,000.00	4,575,000.00
Хүнсний материал	68,721,685.00	73,099,925.00
Бусад хангамжийн материал	157,098,317.00	177,873,836.15
Мал амьтад		
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,286,156,587.75</u>	<u>4,079,799,677.20</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>4,286,156,587.75</u>	<u>4,079,799,677.20</u>
Биет хөрөнгө	4,200,322,837.75	3,993,296,927.20
Барилга, байгууламж, орон сууц	4,087,069,763.64	4,088,404,864.14
Хуримтлагдсан элэгдэл	-639,934,518.06	-753,348,433.74
Машин тоног төхөөрөмж (компьютер)	674,161,704.40	631,287,133.80
Хуримтлагдсан элэгдэл	-208,381,945.41	-218,559,099.84
Тавилга, аж ахуйн эд хогшил	193,937,791.80	209,452,442.00
Хуримтлагдсан элэгдэл	-76,856,047.75	-86,477,237.19
Бусад үндсэн хөрөнгө	298,451,803.25	298,451,803.25
Хуримтлагдсан элэгдэл	-169,146,653.38	-212,765,280.98
Ном	41,020,939.26	36,850,735.76
Биет бус хөрөнгө	85,833,750	86,502,750
Програм хангамж		900,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-635250	-866,250
Бусад биет бус хөрөнгө	86,469,000.00	86,469,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,740,193,537.74</u>	<u>4,467,550,541.20</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>102,089,141.00</u>	<u>222,933,675.00</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>102,089,141.00</u>	<u>222,933,675.00</u>
Өглөг	<u>102,089,141.00</u>	<u>222,933,675.00</u>
Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,727,941.00	180,435,275.00
Бусад өглөг	98,361,200.00	42,498,400.00
Байгууллагад төлөх өглөг	98,361,200.00	42,498,400.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,638,104,396.74</u>	<u>4,244,616,866.20</u>
Засгийн газрын хувь оролцоо	4,638,104,396.74	4,244,616,866.20
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	976,754,083.81	976,754,083.81

Өмч: - төрийн	976,754,083.81	976,754,083.81
Хуримтлагдсан үр дүн	2,072,653,646.14	1,685,652,636.60
Өмнөх үеийн үр дүн	2,072,653,646.14	2,082,721,067.14
Тайлант үеийн үр дүн	00.00	-397,068,430.54
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,588,696,666.79	1,582,210,145.79
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,740,193,537.74	4,467,550,541.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,058,360,014.30	4,412,463,273.70
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	357,738,214.30	144,242,743.70
Нийтлэг татварын бус орлого	357,738,214.30	144,242,743.70
Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,732,900.00	25,057,790.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,673,700.00	5,443,900.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,059,200.00	19,613,890.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	313,100,021.70	94,789,283.10
Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-бараа материал	38,905,292.60	24,395,670.60
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,700,621,800.00	4,268,220,530.00
Улсын төвлөрсөн төсвөөс	3,204,507,100.00	3,831,043,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,204,507,100.00	3,831,043,100.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	496,114,700.00	437,177,430.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага	496,114,700.00	437,177,430.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3,830,106,129.19	4,797,145,320.74
УРСГАЛ ЗАРДАЛ	3,830,106,129.19	4,797,145,320.74
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,725,230,994.19	4,646,211,355.74
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,423,160,364.48	3,030,889,209.23
Цалин	1,508,630,578.70	1,812,631,668.40
Нэмэгдэл цалин	800,110,137.40	1,037,269,241.13
Унаа хоолны хөнгөлөлт	-	85,292,397.62
Урамшуулал	114,419,648.38	95,695,902.08
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	304,426,279.86	364,593,426.73
Тэтгэврийн даатгалын шимтгэл	206,883,179.86	243,160,547.05
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	24,385,800.00	30,376,605.86
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	12,192,900.00	15,274,214.17
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	12,192,900.00	15,156,351.93
Эрүүл мэндийн даатгалын хураамж	48,771,500.00	60,625,707.72

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	470,617,410.65	589,337,834.00
Гэрэл цахилгааны зардал	23,650,610.65	34,597,506.00
Түлш, халаалтын зардал	441,966,800.00	544,740,328.00
Цэвэр, бохир усны зардал	5,000,000.00	10,000,000.00
Хангамж, бараа материалын зардал	30,100,200.00	19,363,321.45
Бичиг хэргийн материал	5,153,450.00	5,222,500.00
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	24,006,500.00	11,092,900.00
Бараа материал актасны зардал	940,250.00	3,047,921.45
Нормативт зардал	150,596,841.50	180,329,475
Эм	2,210,000.00	1,861,450.00
Хоол	148,386,841.50	178,468,025.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		
Эд хогшил, урсгал засварын зардал	31,000,000.00	33,200,830.00
Урсгал засвар	31,000,000.00	33,200,830.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	25,007,699.10	37,880,134.18
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,600,800.00	5,433,900.00
Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	20,406,899.10	32,446,234.18
Бараа үйлчилгээний бусад зардал	290,322,198.60	390,617,125.15
Бараа үйлчилгээний бусад зардал	30,647,386.98	44,519,885.00
Хичээл, сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	20,156,500.00	14,737,450.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	239,518,311.62	331,359,790.15
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104,875,135.00	150,933,965.00
Бусад урсгал шилжүүлэг	104,875,135.00	150,933,965.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	94,077,535.00	125,860,165.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	10,797,600.00	25,073,800.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	228,253,885.11	(384,682,047.04)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	4,623,115.50	12,386,383.50
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,623,115.50	4,170,203.50
Үнэ төлбөргүй гарсан зардал		8,216,180.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(4,623,115.50)	(12,386,383.50)
НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	223,630,769.61	(397,068,430.54)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Хүснэгт 3. Өмч өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	976,754,083.81	1,588,696,666.79	1,844,302,497.17	4,409,753,247.77
2	Тайлант үеийн үр дүн			(397,068,430.54)	(397,068,430.54)
3	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	976,754,083.81	1,582,210,145.79	413,184,416.40	4,244,616,866.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Хүснэгт 4. Мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,706,614,300.00	4,293,278,320.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,992,500.00	25,057,790.00
Нийтлэг татварын бус орлого	5,992,500.00	25,057,790.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,992,500.00	25,057,790.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,933,300.00	5,443,900.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,059,200.00	19,613,890.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,700,621,800.00	4,268,220,530.00
Улсын төвлөрсөн төсвөөс	3,204,507,100.00	3,831,043,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,204,507,100.00	3,831,043,100.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	496,114,700.00	437,177,430.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	496,114,700.00	437,177,430.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	3,678,402,676.54	4,367,711,100.02
УРСГАЛ ЗАРДАЛ	3,678,402,676.54	4,367,711,100.02
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,560,170,001.54	4,216,830,870.02
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,415,129,738.46	3,030,595,508.33
Үндсэн цалин	1,500,599,952.68	1,812,337,967.50
Нэмэгдэл	800,110,137.40	1,037,269,241.13
Унаа хоолны хөнгөлөлт	-	85,292,397.62
Үр дүнгийн урамшуулал	114,419,648.38	95,695,902.08
Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	304,821,900.00	379,427,462.51
Тэтгэврийн даатгалын шимтгэл	207,278,800.00	257,994,582.83
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	24,385,800.00	30,376,605.86
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	12,192,900.00	15,274,214.17
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	12,192,900.00	15,156,351.93
Эрүүл мэндийн даатгалын хураамж	48,771,500.00	60,625,707.72
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	465,114,700.00	414,605,500.00
Гэрэл цахилгааны зардал	19,947,900.00	32,693,200.00
Түлш, халаалтын зардал	440,166,800.00	371,912,300.00
Цэвэр, бохир усны зардал	5,000,000.00	10,000,000.00
Нормативт зардал	165,947,777.00	182,900,000.00
Хоол, хүнс	165,947,777.00	182,900,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	31,000,000.00	22,571,930.00
Урсгал засвар	31,000,000.00	22,571,930.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,007,699.10	56,560,534.18
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4,600,800.00	5,433,900.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,406,899.10	51,126,634.18
Бараа үйлчилгээний бусад зардал	153,148,186.98	130,169,935.00
Бараа үйлчилгээний бусад зардал	132,991,686.98	114,355,235.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	20,156,500.00	15,814,700.00

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	118,232,675.00	150,880,230.00
Бусад урсгал шилжүүлэг	118,232,675.00	150,880,230.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	107,435,075.00	125,806,430.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	10,797,600.00	25,073,800.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	28,211,623.46	(74,432,780.02)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,648,000.	34,383,800.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,648,000.	34,383,800.00
Дотоод эх үүсвэрээр	4,648,000.00	34,383,800.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,648,000.00	34,383,800.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(4,648,000.00)	(34,383,800.00)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	23,563,623.46	(108,816,580.02)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	154,811,415.26	178,375,038.72
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	178,375,038.72	69,558,458.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгт 5. төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	4,553,450,400.00	4,293,278,320.00	260,172,080.00	94.3%
Улсын төсвөөс	3,933,847,600.00	3,831,043,100.00	102,804,500.00	97.4%
Орон нутгийн төсвөөс	441,605,500.00	437,177,430.00	4,428,070.00	99.0%
Туслах үйл ажиллагааны орлого	0.00	19,623,890.00	-19,623,890.00	
Төсөвт байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого	0.00	5,433,900.00	-5,433,900.00	
Урд оны үлдэгдлээс санхүүжүүлэх	177,997,300.00	0	177,997,300.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,553,450,400.00	4,293,278,320.00	260,172,080.00	94.3%
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,553,450,400.00	4,402,094,900.03	151,355,499.97	96.7%
Ажиллагчидтай холбогдсон зардал	3,541,533,900.00	3,410,022,970.85	131,510,929.15	88.8%
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,146,837,400.00	3,030,595,508.33	116,241,891.67	96.9%
Цалин	1,946,341,600.00	1,812,337,967.50	134,003,632.50	93.1%
Цалингийн тусгай нэмэгдлүүд	1,200,495,800.00	1,218,257,540.83	-17,761,740.83	96.7%
Нийгмийн хамгааллын шимтгэл	394,696,500.00	379,427,462.52	15,269,037.48	95.2%
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	331,545,000.00	318,801,754.80	12,743,245.20	96.1%
Эрүүл мэндийн даатгалын хураамж	63,151,500.00	60,625,707.72	2,525,792.28	96.0%
Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал	414,605,500.00	414,605,500.00	0.00	100.0%
Гэрэл цахилгааны зардал	32,693,200.00	32,693,200.00	0.00	100.0%
Түлш, халаалтын зардал	371,912,300.00	371,912,300.00	0.00	100.0%
Цэвэр, бохир усны зардал	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0%

Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	438,614,100.00	426,586,199.18	12,027,900.82	82.3%
Хоол	182,900,000.00	182,900,000.00	0.00	100.0%
Бусад бараа үйлчилгээний зардал	153,377,000.00	148,739,035.00	4,637,965.00	97%
Мэдээллийн технологийн зардал	54,088,500.00	51,126,634.18	2,961,865.82	94.5%
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	15,814,700.00	15,814,700.00	0.00	100%
Урсгал засварын зардал	27,000,000.00	22,571,930.00	4,428,070.00	84%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,433,900.00	5,433,900.00	0.00	100.0%
Урсгал шилжүүлэг	158,696,900.00	150,880,230.00	7,816,670.00	
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	133,623,100.00	125,806,430.00	7,816,670.00	94.2%
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	25,073,800.00	25,073,800.00	0.00	100.0%
Төвлөрүүлэх шилжүүлэг		0.00	0.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		178,375,038.72	-178,375,038.72	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		69,558,458.70	-69,558,458.70	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Завсрын аудитаар 51,672.1 мянган төгрөгийн алдаа¹, зөрчил илрүүлэн, 31,597.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 20,074.4 мянган төгрөгийн алдааг залруулсан. Зөвлөмжийн хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад бүрэн хэрэгжүүлсэн байлаа.

Аудитаар нийт 63,496.7 мянган төгрөгийн алдаа² илэрснээс аудитын явцад 63,496.7 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- ✓ Санхүүгийн байдлын тайланд 4,496.7 мянган төгрөгийн, үр дүнгийн тайланд 46,900.0 мянган төгрөгийн, мөнгөн гүйлгээний тайланд 12,100.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг нягтлан бодогч зөвшөөрч залруулга хийсэн.

Аудитаар нийт 869,894.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлэн, 869,894.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

3.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Тус байгууллага 4,212.0 мянган төгрөгийн хүүхэд хамгааллын зардлыг төлөвлөж тайлагнасан боловч анхан шатны баримтыг бүрдүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

цахим гарын үсгээр баталгаажсан байна” гэж заасныг зөрчсөн, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

1. Хүүхэд хамгааллын зардлын анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж хэвших

Илрүүлэлт:

2. Эд хариуцагч нь тайлант оны бараа материалын тайланг сар бүрийн эцэст гаргаагүй, 2 сараар нь нэгтгэн 6 удаа гаргасан, нягтлан бодогч нь бараа материалын тайланг шалгаж тооцоо бодоогүй байна. Энэ нь тус сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөөгүй, тасалбар болголт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна

Өгсөн зөвлөмж:

2. Эд хариуцагчид бараа материалын тайланг тус сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд үнэн зөв гаргах, нягтлан бодогчид эд хариуцагчийн гаргасан бараа материалын тайланг шалгаж, тооцоо бодсон баримт үйлдэж хэвших үүргүүдийг хүргүүлэн биелэлтийг тооцох

Илрүүлэлт:

3. Хоол зүйчийн боловсруулсан технологийн карт болон 7 хоногийн цэсний боловсруулах үйл явц шаардлага хангаагүй, 1 өдрийн хоолны өртгийн тооцоо хийдэггүй, дээж устгалтын болон ул мөрийг мөрдөн тогтоох журналуудыг бүрэн хөтлөөгүй, тогооч нарын хоолны цэсний мөрдөлтөд хяналт тавиагүй, сурагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч дүн шинжилгээ хийгээгүй байна. Энэ нь Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 6.6-д “Сургуулийн хоол зүйч сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг удирдан зохион байгуулж, суралцагч, ажилтан, эцэг, эхэд мэргэжлийн зөвлөгөөг өгнө”, 9.1.4-д “сургуулийн хоол үйлдвэрлэлийн хүнсний хангамжийн талаар сургуулийн захиргаанд захиалга, хүсэлт, шаардлага гаргах” гэснийг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

3. Үдийн хоолны тогооч нарт хоол зүйчийн боловсруулсан технологийн карт, цэсийг үйл ажиллагаандаа мөрдөж, баримтжуулж хэвших, хоол зүйчид сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зохистой дадал нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих үүргийг хүргүүлэн, биелэлтийг тооцох

Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Шилэн дансны цахим системд батлагдсан төсвийг 619,602.3 мянган төгрөгөөр, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг 246,079.7 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 6.4.5-д заасан мэдээллийг энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй

Өгсөн зөвлөмж:

1. Шилэн дансны цахим системд батлагдсан төсөв, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ зэргийг үнэн зөв, бүрэн мэдээлэх;

Илрүүлэлт:

2. Байгууллагад 2025 оны 10, 12 дугаар сард гарсан сул орон тооны мэдээллийг нийтэд зарлаагүй, ажлаас чөлөөлсөн ажилтныг буцаан томилохдоо хугацаатай гэрээг байгуулаагүй байна. Энэ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1-д “Мэдээлэл хариуцагч ажлын байрны сул орон тооны талаарх

Мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана.” гэж заасныг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй

Өгсөн зөвлөмж:

2. Байгууллагад гарсан ажлын байрны сул орон тооны мэдээллийг хуулийн хугацаанд нийтэд зарлах, ажлаас чөлөөгдсөн ажилтныг буцаан томилохдоо хугацаатай гэрээ байгуулан, цалин хөлсийг олгох;

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 25 -ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Хүснэгт 6. Завсрын аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн	1	51,672.1			1	20,074.4	1	20,074.4			1	31,597.7
Дүн	1	51,672.1			1	20,074.4	1	20,074.4			1	31,597.7

Хүснэгт 7. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн	1	63,496.7			1	63,496.7	1	63,496.7				
Дүн	1	63,496.7			1	63,496.7	1	63,496.7				

Хүснэгт 8. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
хүүхэд хамгааллын зардлыг төлөвлөж тайлагнасан боловч анхан шатны баримтыг бүрдүүлээгүй	1	4,212.0						1	4,212.00
Эд хариуцагч нь тайлант оны бараа материалын тайланг сар бүрийн эцэст гаргаагүй, 2 сараар нь нэгтгэн 6 удаа гаргасан, нягтлан бодогч нь	1	0						1	0

бараа материалын тайланг шалгаж тооцоо бодоогүй байна								
Дүн	2	4,212.0					2	4,212.0

Хүснэгт 9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлээгүй	1	865,682.1					1	865,682.
Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой								
2025 оны 10, 12 дугаар сард гарсан сул орон тооны мэдээллийг нийтэд зарлаагүй	1	0					1	0
Хоол зүйчийн ажил шаардлага хангаагүй	1	0					1	0
Дүн	3	865,682.1					3	865,682.1